

**Ардын зарга нь улс төрийн оролцооны  
нэгэн хэлбэр мөн**  
*/түүхийн социологийн шинжилгээ /*

Докторант Ч.Тамир  
*/МУИС-ийн Социологийн тэнхмийн багш/*

Уламжлалт нийгэм дэх Монголчуудын улс төрийн оролцооны нэгэн хэлбэр нь ардын зарга юм. Зарга хийх нь улс төрийн оролцооны түгээмэл хэлбэрийн болох хувьдаа улс төрийн оролцооны бусад хэлбэрээс ялгагдах ихээхэн онцлог шинжтэй, нарийвчлан судлах шаардлагатай байдаг. Тийм ч учраас миний бие Манжийн ноёрхлын үе буюу 1750-1911 он хүртэлх заргуудыг контент анализын аргаар сонирхон судалж үзсэн юм.<sup>1</sup> Мөн 1911-1919 он хүртэл хугацаанд гарсан ардын заргуудыг шинжлэн үзсэн болно. Хэдийгээр ийм сонирхолд хөтлөгдсөн боловч надад түүхийн баримт сэлтийг шууд эх сурвалжаас нь ашиглах чадвар мөхөсдсөн тул судалгааны бүхий л шаардлагатай баримт сэлт, эх сурвалжийг хангалттай үзэж чадаагүйдээ хүлцэл өчье.

Чухамдаа ардын заргыг судлан үзэхдээ<sup>2</sup> баримт бичиг судлах аргын нэгэн төрөл болох контент анализын аргыг ашиглан, мэдээллийг цуглуулж боловсруулан дүгнэсэн болно.

Ингээд дээрх судалгаан дээр тулгуурлан, монголчуудын улс төрийн оролцооны өвөрмөц хэлбэр болох заргын талаар дараах зүйлийг өгүүлж болохоор байна.

**Нэг. Зарга хийгчид хэн байв?**

Энэхүү асуултанд хариулахын тулд зарга хийж байсан хүмүүсийн нийгмийн бүрэлдхүүнийг нарийвчлан судлан үзэх шаардлагатай юм. Үүнд зарга хийж байсан иргэдийн социал зарим үзүүлэлтүүдээс дурдвал 31-40 эргэм насныхан зонхилж, эрэгтэйчүүд 90 гаруй хувийг нь эзэлж байв. Эдгээр үзүүлэлтүүд нь Монгол орны тухайн үеийн хөгжлийн төвшин амьдралын нөхцөл байдал зэрэгтэй шууд холбоотой гэдэг нь ойлгомжтой юм.

Зарга хийж буй бүлгийн гишүүдийн тооны хувь ч гэсэн харилцан адилгүй байв. Тухайлбал судалгаанд хамрагдагсдын 23.8 хувь нь дангаараа заргалдсан байхад 30.9 хувь нь 2-10 хүний бүрэлдхүүнтэй жижиг бүлгээр, 23.8 хувь нь 21-40 хүнтэй томоохон бүлгээр 11 хувь нь 11-20 хүнтэй дунд зэргийн бүлгээр 4.7 хувь нь 41-100 хүртэл хүмүүс зохион байгуулалтанд орж заргалдаж байжээ.

Ганцаарчилан зарга хийх улс төрийн оролцооны хэлбэр нь уламжлалт нийгэмд ихээхэн түгээмэл байсан нь судалгаанаас харагдаж байгаа боловч тэд дангаараа тэмцээд үр дүнд хүрэх нь ховор байв. Мөн шинж чанарын хувьд цэвэр хувийн шинжтэй байх нь цөөнгүй тохиолдоно.

Шигтгээ: *Түүхийн судалгааны бүтээлүүдээс харахад ардууд ганцаарчилан тэмцэх явдал цөөнгүй байсан. Тухайлбал Олноо өргөгдсөн 8-р он буюу 1918 оны 8-8-ны баримтаар Сайн ноён хан аймгийн Бишрэлт бэйсийн хошууны туслагч Жүрмэддамба нь албан тушаалаа буруугаар ашиглан, Маахүү гэгч эмэгтэйгээс хууль бусаар эд агуурс, үхэр мал булаан авсан учир тэрхүү эмэгтэй Маахүү нь харгис авилгагч түшмэлийг эсэргүүцэн тэмцжээ.*<sup>3</sup>

Харин бүлгээр зарга хийх хэлбэр нь уламжлалт монголын нийгэмд түгээмэл орших ба түүх судлаачид уг асуудалд анхаарлаа хандуулан судлаж олон бүтээл

<sup>1</sup> Эмхэтгэсэн Ц.Насанбалжир Ш.Нацагдорж. Ардын заргын бичиг. 1953.

<sup>2</sup> Эмхэтгэсэн Ц.Насанбалжир Ш.Нацагдорж. Ардын заргын бичиг. 1953.

<sup>3</sup> Б.Ширэндэв. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 1966 82 х.

туурвижээ.<sup>4</sup> Ардын заргад зарга хийгч бүлэг нь 300 гаруй хүртэл хүнтэй томоохон бүлэг хөдөлгөөн болох ч явдал ч гарч байв.

*Шигтгээ: 1837-аад оны үед Сэцэн хан аймгийн ван Тогтохтөрийн хошуунд гарсан заргад 300 орчим ардууд оролцсон байна.*<sup>5</sup>

Заргалдагч бүлэг нь бүрэлдэхүүний хувьд холимог заримдаа ардууд дангаар, мөн тайж, лам нар, занги, бичээч зэрэг албан тушаалтнууд, язгууртан хэргэмтнүүд оролцож байсан нь баримттай зүйл юм. Бүлгийн гишүүд нь харилцан адилгүй нийгмийн статустай хүмүүсээс бүрдэж байсан ба үүнд зарим үед хошуу туслагч хүртэл нийлэн нэгдэх явдал тохиолдож байв.

*Шигтгээ: 1919 онд Сэцэн хан хурц ван ноён Түдэнтэй 75 хүн заргалдсан бөгөөд тэдний 33 нь ард, 22 нь тайж, 12 лам, 8 нь түшмэл байжээ.*<sup>6</sup>

Гэхдээ ардууд гол цөмийг бүрдүүлдэг байсан тул ардын зарга хэмээн түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Мэдээж энэ нь тухайн заргад харц ардуудын гүйцэтгэж байсан үүргийг хэтрүүлэн үнэлэх үндэслэл болж өгөхгүй юм.

### **Хоёр. Зарга хийх шалтгаан хүчин зүйлүүд юу байсан вэ?**

Ардуудын зүгээс зарга хийх болсон шалтгаан хүчин зүйл олон янзын хэлбэртэй байлаа. Үүнд татвар хэтрүүлэн оноох, хувийн өр төлүүлэх, хээл хахууль авах, хууль бусаар эд агуурс мал авах зарим хүмүүсийг татвараас чөлөөлсөн зэрэг олныг тоочиж болно.

Эдгээр шалтгааныг бид судлахдаа түүхийн баримт бичгүүд дээр дурдагдсан бүхий л тохиолдлуудыг жагсаан бичээд, дараагийн шатанд эдгээр тохиолдлуудыг тодорхой төвшинд бүлэглэсэн юм. Хоёрдугаар шатанд дахин нэгтгэн бүлэглээд эдгээр хүчин зүйлс болгоны давтагдсан хувийг гаргав. Үүнд хамгийн их давтагдсан хэсгээс нь жагсаан авч үзвэл дараах шинжилгээг хийж болохоор байна.

#### **1. Хууль бус үйлдэлтэй холбоотой заргууд:**

Судлагдахуун болгон сонгон авсан нийт заргын 33 хувь нь ноёд татвар илүү татах, 33 хувь нь хувийн өрөө төлүүлэх гэсэн шалтгаан давамгайлсан байна. Ноёдын ихэнхи нь тухайн үед үйлчилж байсан хууль дүрмийг зөрчин татварыг илүү татан, хувьдаа ашиглах явдал түгээмэл байжээ. Энэ нь шинж чанарын хувьд ардуудын мэдлэг боловсрол хомс зэргийг ашиглах явдалтай холбоотой байлаа. Харин хоёр дахь хүчин зүйлийн хувьд ноёд, язгууртнууд ихэвчлэн өөрсдийн хувийн хэрэгцээнд ашигласан зүйлээс үүдсэн өөрсдийн өрийг ардуудаар төлүүлэх явдлаар илэрч байв. Дээрх хоёр хэлбэр нь өөр хоорондоо ялгагдах онцлог нь хувийн өрөө иргэдээр төлүүлэх нь шууд мөлжих шинж чанартайгаараа ялгаатай.

#### **2. Ардыг дарлах эд хөрөнгийг булаан авах:**

Ихэс дээдсийн зүгээс ардын эд хөрөнгийг хууль бусаар булаан авах явдал элбэг тохиолдож байжээ. Энэ нь тэдний заргын бичигт тусч заргын гурван бичиг бүрийн нэгэнд нь ихэс дээдсийн зүгээс хууль бусаар ардын эд хөрөнгийг идэж ашигласан гэсэн гомдол мэдүүлэхэд хүрч байв.

#### **3. Ардууд алба татвар төлж чадахгүй болтлоо ядуурах:**

Энэхүү хүчин зүйл бол ардуудтай шууд өөрсөдтэй нь холбоотой юм. Байгаль цаг уурын нөхцөл, олон янзын алба татвар, хятадын худалдаачдын мөнгө хүүлэл, ноёдын мөлжлөг зэрэгтэй холбоотойгоор ардууд үй олноороо ядуурч, бүхэл бүтэн хошуугаараа үгүйрэн хоосрох явдал газар аваад байлаа. Чухам тийм учраас ардууд алба татвараа төлж чадахгүй болох нь тэднийг удирдлагын тодорхой төвшинд алба татвараас хэлтрүүлэхийг гуйж зарга үүсэхэд хүргэж байв. Тухайлбал, бидний контент анализын

<sup>4</sup> Б.Ширэндэв. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 1966. БНМАУ-ын түүх. II боть. 1968. Ш.Нацагдорж. Халхын түүх. 1953.

<sup>5</sup> Ш.Нацагдорж. Халхын түүх. УБ., 1953. 229 х.

<sup>6</sup> Ш.Нацагдорж. Халхын түүх. УБ., 1953. 229 х.

аргаар авсан судалгаанаас үзэхэд, нийт заргын 28 орчим хувь нь ардууд ногдсон албаа төлж чадахгүй болсон учраас албан татвараас чөлөөлж өгөхийг хүссэн байна.

4. *Ноёдын шудрага бус үйл ажиллагаа:*

Ардуудын зүгээс ноёдын шудрага бус үйл ажиллагаатай тэмцэх нь ардын заргын нэгэн шалтгаан болж байлаа. Тухайлбал, сумын эр дарах, чинээлэг хүнийг хамжлага, баян хүнийг албагүй болгох зэрэг ноёд танил тал, хамаатан саднаа тал тохой татсан, өөрсдийн хувийн эрх ашгаа зодсон үйлдлүүд зарга үүсэхэд хүргэж байв. Судалгаанд хамрагдсан заргын бичгийн 14 хувь нь сумын эр дарах, чинээлэг хүнийг хамжлага болгохтой холбоотой заргууд, 7.1 хувь нь баян хүнийг албагүй болгосон гэсэн гомдлууд оржээ. Энэ нь ардуудын хувьд бас л хүндээр тусч алба тэдний амьдралын байдлыг улам хүндрүүлдэг байсан байна.

*Шигтгээ: 1815 онд Түшээт хан аймгийн засаг хошой чин ван Цэрэндоржийг түүний хошууны сумын занги Эрдэнэ тэргүүтэй ардууд заалдан тэмцжээ. Ардууд ноёнтойгоо заргалдах болсон шалтгаан нь ван Цэдэндорж, данс бүртгэл бүхий сум ардын дотроос баялаг чинээлгийг өөрийн хувийн хамжлагад авч, хамжлагын доторхи ядуу өрхийг суманд шилжүүлэн оруулсан байна. Цэдэндорж сумын алба хаах хөрөнгө чинээ бүхий хүмүүсийг өөрийн хамжлагад авснаас болж, сумын бусад ардын хүчин чинээ мөхөсдөж, ногдсон албыг залгуулан гүйцэтгэх бололцоо тасрахад хүрчээ<sup>7</sup>.*

5. *Хятад худалдаачдын пүүсийн өрийг төлүүлэх:*

Чухамдаа түүхийн судалгааны зохиолуудыг нарийвчлан судалж үзэхэд монголчууд хятад худалдаачдын мөлжлөгт гүнзгий автагдсан байжээ. Монголчуудын хувьд хятад худалдаачдын өр төлбөрийг төлж чадахаа больж, тэдний хооронд гүнзгий зөрчил үүсэх болсон байна. Тийм учраас хятад худалдаачид ардуудаас өөрсдийн өр төлбөрийг богино хугацаанд барагдуулахын тулд ноёдоос дэмжлэг аван, төрийн албадлагын механизмыг ашиглах болсон юм. Ардын заргын бичгийн 20 орчим хувь нь буюу заргын 5 бичиг тутмын нэг нь хятад худалдаачдын пүүсийн өрийг төлүүлэхтэй холбоотой маргаан зарга байна.

6. *Шашин шүтлэгийг гутаан доромжлох:*

Бидний судлан үзсэн заргын бичгийн 16 орчим хувьд нь шашин шүтлэгийг гутаан доромжилсон гэсэн үндэслэлээр ноёдыг буруутгаж байсан баримтууд таарч байна. Үүнийг гүнзгийрүүлэн тухайн үеийн орон нутгийн удирдлага ба лам нарын харилцааг судлаж болох талтай. Ямар боловч тэдгээрийн хооронд багагүй хэмжээний зөрчил байсан гэдэг нь судалгааны эл баримтаас ажиглаж болно.

7. *Бусад:*

Дээр дурдсан хүчин зүйлүүдээс гадна өөр хувийн шинжтэй мөн онцгой тохиолдлууд гарч байжээ. Тухайлбал тухайн орон нутгийн удирдлага нь хятадуудад хар тамхи тариалахад нь тусалсан хэмээн заргалдах явдал гарч байжээ.

Үүнээс үзэхэд зарга үүсэх шалтгааны 80 орчим хувь нь шууд болон шууд бус утгаараа эдийн засгийн агуулгатай байгаа нь судалгааны баримтаас харагдаж байна.

**Гурав. Зарга хийх тэмцэл нь хэний эсрэг хандаж байсан вэ?**

Орон нутгийн буюу дийлэнх нь засаг ноёдын эсрэг тэмцсэн байсан нь тухайн үеийн орон нутгийн удирдлагын анхан шатны субъектээс буюу хошуу ноёдын хувь хүний зан чанар, онцлогоос шууд шалтгаалж байжээ.

**Ардын зарга тэмцлийн зорилго нь нэгэн хошууны хүрээн дотор гарч байсан тул тавьж байсан шаардлага нь мөн л хошууныхаа дотор эргэлдэж байсан тул, засаг ноёныг залхаан шийтгүүлэх, муу ноёныг сайн ноёноор сольж тавих, албан татварыг багасгах, ноёны өр толөхийг эсэргүүцэх зэрэг асуудлуудыг шийдвэрлүүлэхэд чиглэгдэж байжээ. Энд муу ноёныг сайн ноёноор солих гэсэн тэмцэл нь ноёрхогч ангийг бүхэлд нь эсэргүүцэн тэмцэхээс ялгаатай гэдэг нь тодорхой юм.**

<sup>7</sup> БНМАУ-ын түүх. II боть. 1968. 256х.

### Дөрөв. Зарга хэдий хугацаанд үргэлжилдэг байсан вэ?

Заргын тэмцлийн цаг хугацааны хувьд заргууд харилцан адилгүй байв. "Адгийн зарга арав хоногтой" гэгчээр аливаа зарга наад зах нь хэдэн сараас 10 гаруй жил үргэлжлэх, зарим үед удам дамжин заргалдах явдал гарч байв. Зөвхөн нэг удаагийн судалгаагаар заргын үргэлжлэх хугацааг нарийвчлан тогтоох боломжгүй юм.

*Шигтгээ:* Сэцэн хан аймгийн гүн Дугарцэмбэлийн хошууны ардуудаас харьяат засаг Джгарцэмбэлтэй заргалдсан тэмцэл, хамгийн урт удаан хугацаанд үргэлжилжээ. Энэ хошууны ардууд заргаа 1824 оноос Дугарцэмбэлийн эцэг засаг Цэдэвдоржийн үеэс эхэлсэн бөгөөд нэгэн үе намдаж, нэгэн үе ширүүн болох зэргээр бүтэн 18 жил буюу 1842 он хүртэл үргэлжилсэн байна.<sup>8</sup>

Үүнд бидний контент анализын судалгаанд орсон заргуудын 10 орчим хувь нь гурваас дээш удаа заргалдсан хэрэг байв. Хэрвээ зарга шийдэгдэхгүй сунжрах тохиолдол цөөнгүй гарч байв. Мөн зарим заргууд тодорхой хугацаанд завсарлан, улмаар дахин үргэлжлэх явдал тохиолдож байв. Дээр жишээ болгон татсан Дугарцэмбэлийн эсрэг хийсэн зарга, мөн Маньбазартай заргалдсан Аюушын зарга нь хэд хэдэн үе шаттай явагдсанаараа онцлог юм.

Зарга үүссэн цаг хугацааг ангилан үзэх нь судалгааг гүнзгийрүүлэх ач холбогдолтой. Судалгаанаас үзвэл 1720-1799 он хүртэл нийт 9.5 хувь нь хамаарч байгаа бол 1800-1850 он хүртэл нийт заргын 50 хувь нь, 1851-1906 он хүртэл 21.4 хувь, харин үлдсэн нь үүнээс хойшхи үеийг хамаарч байна.

### Тав. Зарга тэмцлийн үр дүн ямар байв?

Заргын тэмцлийн үр дүнгийн хувьд тодорхой амжилтанд хүрч байсан гэдгийг харж болно. Тухай үед үйлчилж байсан хууль дүрмийн дагуу иргэд заргалддаг байсан боловч заргалдсан хүмүүс ямар нэгэн хэмжээгээр шийтгэл амсдаг байсан.

Ялангуяа өгүүлэн байгаа үед ардуудын зүгээс ноёдын эсрэг зарга хийх нь ихэссэн тул Манжийн захиргаанаас зарга хийх явдлыг хууль гарган зогсоохыг эрмэлзэж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

*Шигтгээ.* Тэнгэрийг тэтгэгч хааны үед эзэн ноёнттойгоо заргалдсан ардуудыг нэг сарын хугацаагаар дөнгө дөнгөлж, дараа нь ташуур занчиж айл чуулганд буюу хятадын алс хязгаар мужид цөлж хатуу цээрлүүлнэ. Ийм бологсодийн дээдийг заалдах сурталыг болно хэмээжээ.

Хэрвээ тухайн зарга нь үр дүнд хүрэхгүй бол тэмцлийн дараагийн шатанд шилжих явдал нэг бус удаа гарч байжээ.

*Шигтгээ.* 1903 оноос Засагт хан аймгийн дархан бэйл Манибазарын хошуунд ард Аюушаар толгойлуулсан хөдөлгөөн өрнөсөн байна. Ноёнттойгоо зарга хийж эхэлсэн энэ тэмцэл улмаар зэвсэгт тэмцэл болон хувирч байв.

Мөн тухайн ардууд уйгагүй заргалдсан тохиолдолд зарга тодорхой үр дүнд хүрч байв. Түүхийн судалгааны ном зохиолуудыг шүүж үзэхэд ноёдын цалин пүнлүүг нь хасах, хэргэм зэрэг эвдэх, чуулган даргын тушаалаас бууруулах, илүү татварлан авсан зүйлийг буцаан төлүүлэх, ардуудын хохирлыг барагдуулах зэрэг арга хэмжээг бидэнд мэдэгдэж байгаагаар 10 орчим ноёнд авсан байна.

*Шигтгээ.* 1800 онд Сэцэн хан Санжайдоржтой ардууд 43 зүйлээр заргалдан уг тэмцлийн үр дүнд Санжайдорж чуулган даргын тушаалаас огцорч Сэцэн ханы хэргэмээ авахуулсан байна.<sup>9</sup>

Харин ардуудын хувьд ноёдтой заргалдвал бөгсгүй гэгчээр торгуулах, банздуулах, шаахайдуулах, ташуурдуулах зэргээс гадна заргаа авч чадаагүй үед цөлөгдүүлэх зэрэг хүнд шийтгэл амсдаг байв. Зарга хийгч бүлгийн доторхи тайж зэрэг

<sup>8</sup> Ш.Нацагдорж. Халхын түүх. 1953. 216 х.

<sup>9</sup> БНМАУ-ын түүх. II боть. 1968. 255х.

хэргэмтэй хүмүүст шийтгэл ардуудыг бодвол арай хөнгөн тусдаг байсныг түүхийн судалгааны зохиолуудаас харж болно.

*Шигтгээ: 1837-оноос эхэлсэн Сэцэн хан аймгийн ван Тогтохтөрийн хошуунд гарсан зарга 1842 оны үед дуусч оролцосон бхүй л иргэдийг малаар торгож ташуурдан шийтгэж, толгойлогч Дамиран ба Гэлэгийг зарц болгон, Түдэвийг гэр бүлийн хамт Шандун Хунан мужид цөлснөөр хошуунд гарсан ардын хөдөлгөөн дарагджээ.*<sup>10</sup>

### **Долоо. Заргын шинж чанарт тодотгол хийвэл.**

Иргэд заргын бичгийг бичихдээ үндсэндээ гурван янзын хэлбэрээр бичиж байв. Үүнд нэгдүгээрт он дараалал, тооллын хэлбэрээр бичих, хоёрдугаарт зүйл бүрээр жагсаах, гуравдугаарт дээрх хоёрын аль алийг нь агуулсан гэсэн гурван янзын хэлбэрээр заргын бичгээ тэрлэж байв. Судалгаанд орсон заргын бичгийн 5 орчим хувь нь тухайн үйл явдлыг он цаг хугацааны дарааллын дагуу жагсаан бичсэн байна. Хоёрдугаар хэлбэрийн хувьд 16.6 хувь нь заргалдаж байгаа үйл явдлыг зүйл тус бүрээр нь тоочих байдлаар жагсаан бичжээ. Харин гуравдугаар хэлбэрийн хувьд дээрх хоёр хэлбэрийн аль алийг нь агуулсан байдлаар бичсэн байна. Энэ нь нийт заргын дийлэнхи хэсгийг эзэлж байгаа нь тухайн цаг үеийн зарга бичих загварыг ерөнхийд нь харуулах юм. Мөн 1755-1911 он хүртэлх заргын бичлэгийн арга барил дотроо харилцан адилгүй хэдэн хэдэн үе шатанд хувааж болохуйц сонирхолтой зүйлс ч ажиглагдаж байна.

Тухайн заргад авч үзсэн асуудлын тоо нь янз бүр байна.

Ардын заргыг улс төрийн оролцооны конвенциаль хэлбэрт оруулах дараах хэдэн үндэслэл байна.

1. Ард олны зарга үүсэх болсон шалтгаан ихэвчлэн ноёдын хууль бус үйлдлүүд, жишээлэхэд тухайн үед үйлчилж байсан татварын хэмжээг хошуу засгууд дур мэдэн хэтрүүлэн татдагаас үүдсэн байдаг.
2. Зарга хийх тэмцэл нь ардуудын хувьд тухайн үедээ үйлчилж байсан хуулийн хүрээнд явагддаг. Ингэж тэд дээд шатны удирдлагын нэгжид хуулийн заалтуудын дагуу гомдол гарган заргалддаг байв. Энэ нь тэдний бичсэн заргын бичгийн агуулгад илэрлээ олсон байдаг.
3. Хэрвээ ардын зарга нь тодорхой үр дүнд хүрвэл заргалдсан засаг, хошуу ноёдуудын цалин пүнлүүг хасуулах, хохиролыг буцаан төлүүлэх цаашилбал огцруулах хүртэл арга хэмжээ авдаг байсан зэргийг дурдаж болохоор байна.

### *Найм. Дүгнэлт.*

1. Манжийн эрхшээлийн үеийн монголчуудын улс төрийн оролцооны нэгэн чухал хэлбэр нь ардын зарга байсан байна. Энэхүү ардын заргыг судалж үзэхүл монголчуудын улс төрийн оролцооны талаар багагүй зүйл өгүүлж байна.
2. Ард олны зарга үүсэх болсон шалтгаан ихэвчлэн эдийн засгийн шинжтэй хүчин зүйл голлодог жишээлэхэд тухайн үед үйлчилж байсан татварын хэмжээг хошуу ноёд дур мэдэн хэтрүүлэн авдаг ардууд хуулийн хүрээнд дээд шатны удирдлагын нэгжид гомдол зарга гаргахад хүрч байсан.
3. Дээрх судалгаанаас анхаарал татсан нэгэн зүйл бол XVIII-XIX зуунд иргэдийн заргын 65 орчим хувь нь газар зүйн байршлын хувьд Цэцэн хаан аймагт болж байсан нь бидний анхаарлыг эрхгүй татлаа. Үүнд зарим аймгуудын түүхийн баримт материалууд устаж үгүй болсон зэрэг олон шалтгаан байгаа ч одоогоор илрээд байгаа баримтыг ашиглан Цэцэн хан аймгийн байгал, цаг уурын нөлөөлөл, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, хүн ам мал сүргийн тоо, хятад худалдаачдын тоо зэргийг бусад аймгуудтай харьцуулан нарийвчлан судлах шаардлагатай гэсэн бодолд эрхгүй хүргэж байна.

<sup>10</sup> Ш.Нацагдорж. Халхын түүх. 1953 234 х.

4. Судалгаанаас ажиглагдсан нэг зүйл бол Манжийн ноёрхолд байсан үеийн ардын зарга нь ноёрхогч ангийн эсрэг шууд чиглэсэн тийм шинж чанартай зүйл бага болно. Учир нь муу ноёныг сайн ноёноор солих гэсэн тэмцэл нь ноёрхогч ангийг бүхэлд нь эсэргүүцэн тэмцэхээс ялгаатай гэдэг нь тодорхой юм.

Ардын зарга нь улс төрийн оролцооны конвенциаль хэлбэрт орох бөгөөд чингэхдээ тухайн асуудлыг үнэн зөвөөр шийдээгүй зарим үед зарга нь дараагийн шатны хурц тэмцлийн хэлбэр болох дугуйлан, цаашилбал зэвсэгт бослого, хөдөлгөөн болоход хүрч байжээ. Тиймээс ардын заргыг дугуйлан, зодоон, бослого хөдөлгөөн, дүрвэлт, хэрмэл цагаач болох, шавга босгох зэрэг улс төрийн оролцооны бусад хэлбэрүүдтэй нягт холбон судлах шаардлагатай байна.

**“ The petition of Ards(People) as form of political activities.”**

**Summary**

*Ch. Tamir.*

This is a study the petition as form participation of Mongols in political life. The study illustrates the content analyses, based on historical origins of petition in traditional Mongolian society. The public petition is expression of general tendency of politics. The majority of the petitions had economical motion.